



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/41

Баян-Өндөр сум

Эцэг, эхийн зөвлөлд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар 67.5 дах хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18.1.2 дах хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйл, Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28, 29 дүгээр зүйл, Улсын их хурлын байнгын хорооны хурлын 2018 оны 04 тоот тогтоол, Засгийн газрын 2018 оны 01 тоот албан даалгавар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн хурлын 2018 оны 03 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн дарга Салбарын санхүү бүртгэл, нягтлан бодохын ажилтан Н.Чулуун-Эрдэнэ өөр ажилд томилогдсон тул Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан Б.Батцэцэгээр өөрчлөн томилсугай.

2. Эцэг эхийн зөвлөлийн 2026 оны төлөвлөгөөний дагуу ажлыг эрчимжүүлэн ажиллахыг дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ